



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХЖК-ИЙН 2022 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/102/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Ч.Болд  
Утас: 51-260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn  
Аудитор: Г.Мөнхчимэг  
Утас: 51-261628 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК  
Захирал Н.Дэлгэрмаа  
Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@yahoo.com

Улаанбаатар хот  
2023 он

**АГУУЛГА**

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	13
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	17
5.1 Албан шаардлага.....	17
5.2 Зөвлөмж.....	17
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	19
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	19
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗХ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХС	Эрчим хүчний сайд



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2023 03 15 № 07/517  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211, 2021 оны 410 дугаар тогтоолын дагуу Эрчим хүчний сайд 2020 оны 269 дүгээр тушаалаар "Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам" баталсан байна.

Дээрх журмын 6 дугаар зүйлд заасны дагуу айл өрх, албан байгууллагын цахилгаан эрчим хүч, дулааны төлбөрийг төрөөс хариуцах хөнгөлөлтийн санхүүжилтийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дээд байгууллагын баталсан хуваарийн дагуу 98,431.2 сая төгрөгийг төлсөн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх суудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаарх нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ирүүлсэн нийлүүлэх эрчим хүчний чадал, энергийн саналыг Диспетчерийн үндэсний төв ТӨХХК хянаж, ЭХЭХ нэг худалдан авагчийн загварын тайланд мөрдөх тариф, мөнгөн урсгалын коэффициентийг тогтоон

Z:\Yawsan\_Bichig\2023\0315 SNAG-5 Docx

**0001050873**

Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

баталдаг. Тайлант оны тарифын сөрөг зөрүү 2,176.6 сая төгрөгийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт тайлагнасан байна.

Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч "Клин Энержи" ХХК-тай 2008 онд хийсэн гэрээний хатуу нөхцөл болох "Take or pay" заалт, 2020 оны гэрээний нэмэлт өөрчлөлтөөр жил бүр худалдан авах 164 сая кВт.т цахилгаан эрчим хүчнээс 2022 онд дутуу нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний төлбөрт 538.6 сая төгрөгийг төлж, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэн тайлагнасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



Z:\Yawsan\_Bichig\2023\03\15 SNAG-5 Docx

Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,484,937,901.58	9,862,348,787.10
1.1.2	Дансны авлага	91,384,295,595.78	58,338,523,367.17
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,305,784,093.91	2,328,637,569.28
1.1.4	Бусад авлага	7,725,000.00	105,034,547.31
1.1.5	Бараа материал	245,034,279.77	253,857,867.13
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	102,205,415.27	29,123,424.64
1.1.7	Бусад эргэлтийн хөрөнгө	1,077,298,666.77	-
1.1.8	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>98,607,280,953.08</b>	<b>70,917,525,562.63</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,352,664,560.47	9,326,461,419.05
1.2.2	Биет бус хөрөнгө	3,001,816,424.44	1,903,752,730.23
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	6,879,984,404.15
1.2.4	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>12,354,480,984.91</b>	<b>18,110,198,553.43</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>110,961,761,937.99</b>	<b>89,027,724,116.06</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	93,086,414,936.55	74,477,106,341.46
2.1.1.2	Татварын өр	320,612,266.71	1,149,248,350.25
2.1.1.3	Урьдчилж орсон орлого	21,535,035.74	556,314,279.10
2.1.1.4	Бусад богино хугацаат өр төлбөр	3,868,442,772.71	351,335,342.38
<b>2.1.1.5</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>97,297,005,011.71</b>	<b>76,534,004,313.19</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	-	
2.1.2.1	Урт хугацаат зээл	6,789,019,436.04	6,351,018,099.86
2.1.2.2	Хойшлогдсон татварын өр	914,652,709.34	901,134,608.53
<b>2.1.2.4</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>7,703,672,145.38</b>	<b>7,252,152,708.39</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>105,000,677,157.09</b>	<b>83,786,157,021.58</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	1,811,705,231.02	1,811,705,231.02
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	587,815,153.11	587,815,153.11
2.3.3	Эздийн өмчийн бусад хэсэг	140,628,482.55	140,628,482.55
<b>2.3.4</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>3,420,935,914.22</b>	<b>2,701,418,227.80</b>
2.3.4.1	Өмнөх үеийн ашиг	2,072,997,627.20	2,590,093,485.46
2.3.4.2	Тайлант үеийн ашиг	1,347,938,287.02	111,324,742.34
<b>2.3.5</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>5,961,084,780.90</b>	<b>5,241,567,094.48</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>110,961,761,937.99</b>	<b>89,027,724,116.06</b>

Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>1,016,556,113,363.31</b>	<b>1,103,528,679,427.60</b>
2	Борлуулалтын өртөг	1,016,228,378,941.12	1,109,158,008,060.69
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>327,734,422.19</b>	<b>(5,629,328,633.09)</b>
4	Хүүний орлого	907,383.99	-
5	Торгуулийн орлого	18,423,331.82	-
6	Бусад орлого	752,600,422,749.39	9,961,188,126.94
6.1	<b>Орлогын дүн</b>	<b>752,619,753,465.20</b>	<b>9,961,188,126.94</b>
7	Борлуулалт, маркетингийн зардал	441,948,581.48	578,437,878.13
8	Ерөнхий ба удирдлагын зардал	1,362,069,336.46	1,882,442,165.38
9	Санхүүгийн зардал	141,384,307.45	133,708,862.74
10	Бусад зардал	746,662,671,175.45	868,871,837.06
11	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,693,403,674.24	-
11.1	<b>Зардлын дүн</b>	<b>751,301,477,075.08</b>	<b>3,463,460,743.31</b>
12	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(14,554,310.11)	(675,612,500.04)
13	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	818,181.82	(29,756,461.47)
14	Олз, гарзын дүн	(13,736,128.29)	(705,368,961.51)
15	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>1,632,274,684.02</b>	<b>163,029,789.03</b>
16	Орлогын татварын зардал	284,336,397.00	51,705,046.69
17	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>1,347,938,287.02</b>	<b>111,324,742.34</b>
18	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>1,347,938,287.02</b>	<b>111,324,742.34</b>

**Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан**

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,811,705,231.02</b>	<b>3,406,082.55</b>	<b>587,815,153.11</b>	<b>(9,367,343,521.69)</b>	<b>(6,964,417,055.01)</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	137,222,400.00	-	11,440,341,148.89	11,577,563,548.89
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,811,705,231.02</b>	<b>140,628,482.55</b>	<b>587,815,153.11</b>	<b>2,072,997,627.20</b>	<b>6,612,146,493.88</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,347,938,287.02	1,347,938,287.02
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,811,705,231.02</b>	<b>140,628,482.55</b>	<b>587,815,153.11</b>	<b>3,420,935,914.23</b>	<b>5,961,084,780.90</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(830,842,428.76)	(830,842,428.76)
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,811,705,231.02</b>	<b>140,628,482.55</b>	<b>587,815,153.11</b>	<b>2,590,093,485.46</b>	<b>5,130,242,352.14</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	111,324,742.34	111,324,742.34
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,811,705,231.02</b>	<b>140,628,482.55</b>	<b>587,815,153.11</b>	<b>2,701,418,227.80</b>	<b>5,241,567,094.48</b>

Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**  
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</b>	<b>1,716,828,453,797.83</b>	<b>1,403,474,788,352.37</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	970,903,829,734.28	1,181,097,490,014.88
1.1.2	Даатгалын нөхөн олголт	-	331,200.00
1.1.3	Бусад мөнгөн орлого	745,924,624,063.55	222,376,967,137.49
1.2	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,713,225,674,311.77</b>	<b>1,392,898,188,671.62</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн мөнгө	3,248,553,122.61	4,524,655,124.17
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	852,889,037.03	1,230,528,035.57
1.2.3	Ашиглалтын зардалд төлсөн	561,013,052.46	529,192,858.52
1.2.4	Бараа материал худалдан авахад төлсөн	946,777,021,852.39	1,139,858,101,501.57
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	40,575,144.00	144,792,476.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	141,384,307.45	133,708,862.74
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	15,350,836,043.59	24,934,739,303.44
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	7,935,795.00	12,506,780.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	745,409,742,999.00	221,529,963,729.61
1.2.10	Бараа үйлчилгээний бусад зардал	835,722,958.24	-
1.3	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,602,779,486.06</b>	<b>10,576,599,680.75</b>
2.1	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>	<b>1,807,383.99</b>	<b>-</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	900,000.00	-
2.1.2	Хүлээн авсан хүүгийн орлого	907,383.99	-
2.2	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>3,222,402,570.15</b>	<b>1,967,622,140.61</b>
2.2.1	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,922,074,226.46	-
2.2.2	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	300,328,343.69	1,831,708,936.86
2.2.3	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	135,913,203.75
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(3,220,595,186.16)</b>	<b>(1,967,622,140.61)</b>
3.1	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>4,959,333.23</b>	<b>180,447,308.21</b>
3.1.1	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	4,959,333.23	180,447,308.21
3.2	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	<b>772,537,368.60</b>	<b>3,412,013,962.83</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	722,792,210.39	438,001,336.18
3.2.2	Төлсөн ногдол ашиг	37,814,820.96	673,969,143.00
3.2.3	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	11,930,337.25	2,300,043,483.65
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(767,578,035.37)</b>	<b>(3,231,566,654.62)</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(385,393,735.47)</b>	<b>5,377,410,885.52</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>4,870,331,637.05</b>	<b>4,484,937,901.58</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>4,484,937,901.58</b>	<b>9,862,348,787.10</b>



**Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан**

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл  
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**

№	Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	Цахилгаан эрчим хүч:	Нийт хэрэглээ /Боловсруулалтаар/	сая.кВтц	8,030.0	8,291.2	261.1	103.3
		Боловсруулалт	сая.кВтц	7,513.7	7,745.2	231.4	103.1
		Түгээлтээр	сая.кВтц	6,654.8	6,870.9	216.1	103.2
	Дулааны эрчим хүч:	Боловсруулалт	мян.Гкал	9,803.1	10,063.3	260.3	102.7
		Түгээлтээр	мян.Гкал	9,547.2	9,810.5	263.3	102.8
2	<b>Нийт орлого</b>		<b>төгрөгөөр</b>	<b>10,907,377,600.00</b>	<b>10,791,196,844.20</b>	<b>(116,180,755.80)</b>	<b>98.9</b>
	Үүнээс:	Борлуулалтын орлого	төгрөгөөр	10,198,897,600.00	9,868,897,600.10	(329,999,999.90)	96.8
		Үйл ажиллагааны бус орлого	төгрөгөөр	708,480,000.00	922,299,244.10	213,819,244.10	130.2
3	<b>Нийт зардал</b>		<b>төгрөгөөр</b>	<b>10,906,685,271.90</b>	<b>10,727,048,123.70</b>	<b>(179,637,148.20)</b>	<b>98.4</b>
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	төгрөгөөр	10,296,851,021.90	9,728,337,379.50	(568,513,642.40)	94.5
		Үйл ажиллагааны бус зардал	төгрөгөөр	609,834,250.00	998,710,744.20	388,876,494.20	163.8
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		төгрөгөөр	692,328.10	64,148,720.40	63,456,392.30	-
5	Татварын дараах ашиг /алдагдал/		төгрөгөөр	623,095.30	12,443,673.80	11,820,578.50	
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		төгрөгөөр	999936.5266	994055.4582	(5,881.07)	99.4
7	<b>Нийт авлага</b>		<b>төгрөгөөр</b>	<b>150,000,000.00</b>	<b>295,793,886.00</b>	<b>145,793,886.00</b>	<b>197.2</b>
	Үүнээс:	ЭХ-ний	төгрөгөөр			-	0
		бусад	төгрөгөөр	150,000,000.00	295,793,886.00	145,793,886.00	197.2
8	<b>Нийт өглөг</b>		<b>төгрөгөөр</b>	<b>8,155,000,000.00</b>	<b>7,623,868,708.4</b>	<b>(531,131,291.60)</b>	<b>93.5</b>
	Үүнээс:	УХӨТ	төгрөгөөр	7,755,000,000.00	7,252,152,708.40	(502,847,291.60)	93.5
		БХӨТ	төгрөгөөр	400,000,000.00	371,716,000.00	(28,284,000.00)	92.9
9	Нийт ажилчдын тоо		тоо	120	118	(2.00)	98.3
10	Нийт цалингийн сан		төгрөгөөр	4,965,391,799.80	4,808,825,317.20	(156,566,482.60)	96.8
11	Диспетчерийн үр ашигтай зохицуулалт, горим төлөвлөлт		төгрөгөөр	116.33	122.69	6.36	105.5
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		төгрөгөөр	2,179,136,239.00	2,089,998,015.50	(89,138,223.50)	95.9
	Үүнээс:	Их засвар	төгрөгөөр	354,322,429.00	340,794,138.00	(13,528,291.00)	96.2
		ТЗБАХ	төгрөгөөр	180,257,125.00	175,078,914.50	(5,178,210.50)	97.1
		Хөрөнгө оруулалт	төгрөгөөр	1,644,556,685.00	1,574,124,963.00	(70,431,722.00)	95.7

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК нь “Нэгдсэн сүлжээний дүрэм”-ийн хүрээнд цахилгаан үйлдвэрлэх, импортлох, дамжуулах, түгээх, нийслэл, төвлөрсөн дулаан хангамж бүхий хотуудын дулаан үйлдвэрлэх, дамжуулах үйл ажиллагааг диспетчерийн шуурхай зохицуулалтаар удирдах үйл ажиллагаа явуулдаг, Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Төрийн өмчийн 30.0 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, 70.0 хувийг Эрчим хүчний яам эзэмшиж байна.

Компанийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- “Нэгдсэн сүлжээний дүрэм”-ийн хүрээнд цахилгаан үйлдвэрлэх, импортлох, дамжуулах, түгээх, нийслэл төвлөрсөн дулаан хангамж бүхий хотуудын дулаан үйлдвэрлэх, дамжуулах үйл ажиллагааг диспетчерийн шуурхай зохицуулалтаар удирдах,
- Цахилгаан, дулаан үйлдвэрлэлийн хэмнэлттэй горим төлөвлөгөөг хэрэгжүүлж, нэгдсэн сүлжээний хүрээнд арилжааны үйл ажиллагааг удирдах,
- Салбарын хэмжээнд реле хамгаалалт, автоматикийн байгууламжид хяналт тавьж, системийн тогтвортой ажиллагааг хангахад үнэлэлт, дүгнэлт гаргаж, холбогдох арга хэмжээг авах,
- Үйлдвэрлэгч, дамжуулагч компаниудын технологийн үйл ажиллагааны хяналт мэдээллийн СКАДА системийн тоног төхөөрөмж, компьютерын программ, техник хангамж, диспетчерийн шуурхай холбоо, мэдээллийн сүлжээний бэлэн байдлыг хангаж шинэ техник, технологи нэвтрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх,
- Нэгдсэн сүлжээний арилжааны үйл ажиллагааг удирдан явуулна.

#### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Компанийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 410 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2020 оны 269 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам”.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211, 2021 оны 410 дугаар тогтоолын дагуу Ковид-19 цар тахлын үед айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжид цахилгаан, дулааны эрчим хүчний хөнгөлөлт үзүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгжийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн төлбөрийн гүйцэтгэлд Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын санхүүгийн хяналт шалгалтын хэлтсээс 2022 оны 11 дүгээр сард шалгалт хийж, алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгч, төлбөрийн акт тогтоосон байна.

Эрчим хүчний яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2022 оны 9 дүгээр сард тайлант оны эхний 7 сарын байдлаарх Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд шалгалт хийж, тус байгууллага 98.0 хувийн гүйцэтгэлтэй 3 дугаар түвшинд үнэлэгдсэн байна. Шалгалтын мөрөөр

**Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан**

түвшин ахиулах, зөрчлийг арилгахад арга хэмжээ авч холбогдох ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлэх талаар зөвлөмж ирүүлсэн байна.

Санхүүгийн дотоод хяналтын ажилтан тайлант онд 9 асуудлыг шалгахад төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлсэн. Шалгалтын үр дүнд нийт 23 зөвлөмжийг алба хэлтсүүдэд хүргүүлснээс хариу ирүүлэх хугацаа болоогүй 2, хэрэгжиж байгаа 2, бүрэн хэрэгжүүлсэн 19, нийт 90.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн дотоод хяналтын ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211, 2021 оны 410 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2020 оны 269 дүгээр тушаалаар батлагдсан "Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам"-ын дагуу 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацааны айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийн цахилгаан, дулааны эрчим хүчний хөнгөлөлт, чөлөөлөлтийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлсэн төлбөрийн тооцоо,
- Байгууллагын тайлант оны аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайланд үндсэн хөрөнгө, гадаад валютын ханшийн түр зөрүүгийн бүртгэлийг "ТАХАСС" татварын бүртгэл, тайлагналын онлайн системд оруулсан хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тооцооны бүртгэл.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн 2018 оны 2 дугаар тогтоолоор баталж, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна. Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн 2022 оны 23 дугаар тогтоолоор нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулж, нягтлан бодох бүртгэлийн дансыг улсын хэмжээнд болон эрчим хүчний салбарын хэмжээнд баримтлах дансны жагсаалтад нийцүүлэн кодчилон мөрдсөн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,934.1 сая төгрөгөөр буюу 19.8 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,484.9	9,862.3	5,377.4
Авлага	92,697.8	60,772.1	(31,925.7)
Бараа материал	245.0	253.9	8.9
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	102.2	29.1	(73.1)

**Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан**

Бусад эргэлтийн хөрөнгө	1,077.4	-	(1,077.5)
Үндсэн хөрөнгө	9,352.7	9,326.5	(26.2)
Биет бус хөрөнгө	3,001.8	1,903.8	(1,098.0)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	6,880.0	6,880.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>110,961.8</b>	<b>89,027.7</b>	<b>(21,934.1)</b>
Богино хугацаат өр төлбөр	97,297.0	76,534.0	(20,763.0)
Урт хугацаат өр төлбөр	7,703.7	7,252.2	(451.5)
Эздийн өмч	5,961.1	5,241.5	(719.6)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>110,961.8</b>	<b>89,027.7</b>	<b>(21,934.1)</b>

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, биет бус хөрөнгө, бусад эргэлтийн бус хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, хуримтлагдсан ашгийн данснүүдэд материаллаг дүнгээр өөрчлөлт гарсан байна.

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 9,862.3 сая төгрөг болж, 5,377.4 сая төгрөгөөр өссөн нь нэг худалдан авагчийн тооцооноос хуваарилагдаагүй 604.1 сая, валютын арилжаанаас шалтгаалан импортын цахилгааны 12 дугаар сарын сүүлийн төлбөрийг шилжүүлээгүй 3,966.0 сая, үйл ажиллагааны дансанд төлөгдөөгүй бэлтгэн нийлүүлэгчийн гэрээний үлдэгдэл 119.7 сая, хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэмнэлт 152.8 сая, урьдчилж орж ирсэн орлого 534.8 сая төгрөгийн үлдэгдлүүд нөлөөлсөн байна;
- Авлага дансны нийт үлдэгдэл 60,772.1 сая төгрөг болж 31,925.7 сая төгрөгөөр буурсан нь нэг худалдан авагчийн загварын тооцооны түгээх байгууллагуудын авлагыг бууруулах төлөвлөгөө гаргаж 7 хоног бүрээр гүйцэтгэлийг хянаж ажилласнаар дансны авлага 33,045.8 сая төгрөгөөр буурсан, Импортын хэрэгжээгүй нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоогоор татварын авлага 1,022.8 сая, бусад авлага данс 97.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, түрээсийн байрны барьцаа 15.8 сая, Ховдын ДЦС-д олгосон түр санхүүжилт 83.9 сая төгрөгийн үлдэгдэл байна;
- Бараа материал дансны үлдэгдэл 253.9 сая төгрөг болж, 8.9 сая төгрөгөөр өссөн нь сэлбэг хэрэгслийн нөөц нэмэгдсэнтэй холбоотой байна;
- Урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 29.1 сая төгрөг болж 73.1 сая төгрөгөөр буурсан нь өмнөх жил оффисын барилга барихаар ТЭЗҮ хийлгэсэн 100.5 сая төгрөгийг барилга барих эх үүсвэр шийдэгдээгүй тул өмнөх оны зардлаар тайлагнасан байна;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 9,326.5 сая төгрөг болж, 26.2 сая төгрөгөөр буурсан. Тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 1,709.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, ТӨБЗГ-ын 2022 оны А-1/2580 дугаар тогтоолын дагуу 38.3 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 383 дугаар тогтоолын дагуу 69.2 сая төгрөгийн автомашиныг балансаас балансад шилжүүлсэн. Тайлант хугацааны элэгдлийн зардал 1,628.0 сая төгрөг тайлагнасан байна;
- Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 1,903.8 сая төгрөг болж, 1,098.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 128.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, ТӨБЗГ-ын 2022 оны А-1/2580 тогтоолын дагуу 41.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант оны хасагдуулага 1,184.9 сая төгрөгийг тайлагнасан байна;
- Бусад эргэлтийн бус хөрөнгө дансны үлдэгдэл 6,879.0 сая төгрөг болж, 5,802.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нэг худалдан авагчийн тооцооны тарифын сөрөг зөрүү 2,174.3 сая, импортолсон цахилгаан эрчим хүчний төлбөрийн гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз 3,628.3 сая төгрөгийг тус тус нөөц хөрөнгөөр бүртгэсэнтэй холбоотой байна;
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 76,534.0 сая төгрөг болж, 20,763.0 сая төгрөгөөр буурсан. Дансны өглөг нийт дүнгээр 18,609.3 сая төгрөгөөр буурсан нь Нэг худалдан авагчийн загварын тооцооны үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын орлогын хуваарилалт өмнөх оноос 5.0 хувь өсөж тооцооны өглөг 38,215.0 сая төгрөгөөр буурсан, импортын цахилгаан эрчим хүчний төлбөр валютын ханшийн зөрүү болон хэрэглээний өсөлтөөс шалтгаалан 19,585.3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Татварын өр төлбөр дансны үлдэгдэл 828.6 сая төгрөгөөр өссөн нь 2022 оны 12 дугаар сарын импортын нэмэгдсэн өртөг, гаалийн албан татварын өрийг төлөөгүй байна. Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 534.8 сая төгрөгөөр өссөн нь диспетчерийн зохицуулалтын илүү төлөгдсөн орлого 505.1 сая, төлбөрт үйлчилгээний

**Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан**

урьдчилгаа төлбөр 51.2 сая төгрөг байна. Бусад богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 351.3 сая болж, 69.2 сая төгрөгөөр өссөн нь бэлтгэн нийлүүлэгчдийн гэрээний нөхцөлийн дагуу барьцаат өглөгүүдийг бүртгэсэн байна;

- Урт хугацаат өр төлбөрийн дансны нийт үлдэгдэл 7,252.2 сая төгрөг болж 451.5 сая төгрөгөөр буурсан. Урт хугацаат зээлийн өглөг данс 438.0 сая төгрөгөөр буурсан нь Германы сэргээн босголтын банкны эх үүсвэртэй Сангийн яаманд дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу тайлант оны зээлийг төлсөн. Нөөц өр төлбөрийн дансны үлдэгдлийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авсан үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардал 124.6 сая төгрөгөөр бууруулан бүртгэсэн. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал болон гадаад валютын ханшийн түр зөрүүгээс үүссэн 111.1 сая төгрөгөөр хойшлогдсон татварын өр төлбөрийг бүртгэсэн байна;
- Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл нийт дүнгээр 719.5 сая төгрөгөөр буурсан байна. ТӨБЗГ-ын 2022 оны 307 дугаар тогтоолоор баталсан өмнөх оны ногдол ашигт 674.0 сая төгрөгийг улсын төсвийн орлогын дансанд төвлөрүүлж, өмнөх онд урьдчилж төлсөн зардлаар тайлагнасан барилгын техникийн зөвшөөрлийн 100.5 сая, татварын зөрүүгийн тооцооллоос 56.3 сая, нийт 830.8 сая төгрөгийг өмнөх үеийн хуримтлагдсан ашгийг бууруулан залруулсан. Тайлант оны цэвэр ашиг 111.3 сая төгрөгийг тайлагнасан байна.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн орлогын дэлгэрэнгүй тайлангаар нийт орлого өмнөх оноос 89,724.7 сая төгрөгөөр буюу 8.8 хувиар өссөн байна. Үүнд:

- Нэг худалдан авагчийн загварын тооцооны борлуулалтын орлого 86,862.4 сая;
- Диспетчерийн зохицуулалтын борлуулалтын орлого 110.2 сая;
- Нэг худалдан авагчийн загварын тооцооны диспетчерийн зөрчлийн төлбөр, график хазайлт, алданги торгуулийн орлого 2,447.2 сая;
- Диспетчерийн үйл ажиллагааны бусад орлого 304.9 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 90,501.4 сая төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэг худалдан авагчийн загварын тооцооны борлуулсан бүтээгдэхүүний өртөг, диспетчерийн зохицуулалтын үйл ажиллагааны үндсэн болон нэмэгдэл цалин, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлууд байна. Үүнд:

- Нэг худалдан авагчийн загварын тооцооны борлуулсан бүтээгдэхүүний өртөг цахилгаан эрчим хүчний хэрэглээ 389.9 МВтц-р өссөн, мөн дайны нөлөөллөөр Оросын холбооны улсын эсрэг авч байгаа олон улсын эдийн засгийн хориг арга хэмжээнээс шалтгаалан долларын ханш өссөн, долларын хомсдол үүссэнтэй холбоотой 88,630.5 сая;
- Диспетчерийн зохицуулалтын борлуулалтын өртөг өмнөх онд Техник хяналтын алба, Мэдээлэл технологийн төв шинээр үүсэж бүтэц орон тоонд өөрчлөлт орсонтой холбоотой цалин, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өсөж 1,605.1 сая;
- Ерөнхий удирдлагын болон Борлуулалт маркетингийн зардал өртгийн төвийг шинэчилсэнтэй холбоотой цалин, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын хуваарилалтууд өсөж 658.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.
- Бусад зардал өмнөх онд татварын актын төлбөр төлсөнтэй холбоотой 392.4 сая төгрөгөөр буурсан байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ТӨХХК нь техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ болон ЭХС-аар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК -ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 27 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2022 оны А/15 дугаар тушаалаар, диспетчерийн зохицуулалтын тарифыг Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 24 дүгээр тогтоолоор тус тус батлуулсан.

Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

Тайлант оны нийт орлогыг 12,936.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 12,935.7 сая төгрөгөөр, 0.6 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 3,967.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 388 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 18 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2022 оны А/145 дугаар тушаалаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийсэн байна. Тодотголоор нэмэлт ажил үйлчилгээний орлогыг 110.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлыг 2,179.3 сая төгрөг хэмнэхээр хасч батлуулсан байна.

Эрчим хүчний зохицуулах хороотой 2021 онд байгуулсан Урамшуулалт зохицуулалтын гэрээний дагуу олсон орлогыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үндсэн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтад зарцуулах шаардлагын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 27 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2022 оны А/212 дугаар тушаалаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд дахин тодотгол хийгдсэн.

Тодотголоор тайлант оны орлогыг 2,028.9 сая төгрөгөөр бууруулан 10,907.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,028.9 сая төгрөгөөр бууруулан 10,906.7 сая төгрөг болгон тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 10,791.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 10,727.0 сая төгрөгийн зардал гарган, 64.2 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 10,791.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 116.2 сая төгрөг буюу 1.1 хувиар тасарсан нь Эрчим хүчний зохицуулах хорооноос Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 330.0 сая төгрөгийг диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний орлогоос бууруулсныг төлөвлөгөөнд тодотгол хийлгээгүйгээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 10,727.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 179.6 сая төгрөг буюу 1.6 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Эрчим хүчний сайдын 2022 оны А/212 дугаар тушаалаар үндсэн бус үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэн баталсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 26 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 1,996.3 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 111.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 110.7 сая төгрөгөөр илүү байгаа нь үндсэн бус үйл ажиллагааны орлогын өсөлт нөлөөлжээ.

ТӨБЗГ-т тайлант онд ногдол ашгийн 674.0 сая төгрөг төгрөгийг төвлөрүүлжээ.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ТӨХХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Диспетчерийн үндэсний төв ТӨХХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтад нэг худалдан авагчийн загварын авлага, өглөгийн насжилтыг тодорхойлохтой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд хийгдсэн худалдан авалтын үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн эсэхийг тендерийн баримт материалтай тулган шалгахад зөрчилгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомж, худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хууль тогтоомжийн заалттай тус тус нийцсэн, жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар нийт 75,469.4 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илрүүлснээс, 75,334.1 сая төгрөгийн 3 алдааг залруулах зөвлөмж өгч, 135.3 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр төлөвлөсөн.

Өгсөн зөвлөмж, шаардлагыг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 921.4 сая төгрөгийн 2 алдааг бүрэн залруулж, жилийн эцсийн аудитаар нэг худалдан авагчийн загварын тооцооны авлага өглөгийн насжилтын бодлогыг тодорхойлох шинж чанарын хувьд материаллаг 1 алдааг сайжруулах 1 зөвлөмж, нэмэлт ажил үйлчилгээний орлогоос ашгийн түвшинтэй уялдуулан оновчтой зөв хуваарилаагүй урамшуулалт цалин олгосон 415.5 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр тогтсон.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар орон тоо төсөв батлагдаагүй албан тушаалтанд олгосон цалин 9.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зорилтот түвшнийг оновчтой төлөвлөөгүй 646.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, өртөг зардлыг зөв хуваарилан бүртгэх бодлогыг сайжруулах, нэмэгдсэн өртгийн албан татварын тооцооллыг зөв тайлагнах, нэмэлт ажил үйлчилгээний орлого ашгийг зөв хуваарилан тайлагнах талаар 294.8 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	9.0	1	9.0	100.0
Албан шаардлага	1	646.3	1	530.1	82.0
Зөвлөмж	3	294.8	3	294.8	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>950.1</b>	<b>5</b>	<b>833.9</b>	<b>94.0</b>

Өмнөх аудитаар нэмэлт ажил үйлчилгээний орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн, төсөвт батлагдаагүй зардлыг тайлагнасан, дараагийн онд гарах зардлыг төсөвт оруулан баталсан зэрэг 646.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Тайлант онд орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр 116.2 сая төгрөгөөр тасалж, зөрчил 82.0 хувиар буурсан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 15 дугаар тогтоолоор баталсан "Нэмэлт ажил үйлчилгээ зохицуулах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2-д "Тухайн гэрээт ажилд шаардлагатай зардлыг тус ажил үйлчилгээний орлогоос санхүүжүүлэх ба санхүүгийн нэгж цэвэр

ашгийг тодорхойлно. Санхүүгийн нэгж нь зардлын холбогдох баримтыг бүрдүүлж, ашиглагдсан биет болон биет бус хөрөнгийн элэгдлийг тооцон, цэвэр ашгийн тодорхойлолтыг дэлгэрэнгүй тайлбарын хамт захирлын зөвлөлийн хуралд танилцуулна" гэж заасны дагуу гэрээний гүйцэтгэлд хамаарах цалин бусад зардлыг давхардуулалгүй оновчтой хуваарилан бүртгэж, цэвэр ашгийг зөв тооцоолсон эсэх, журмыг шинэчлэн боловсронгуй болгосон эсэхийг дараагийн аудитаар шалгана.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 100.5 сая төгрөгийн 2 алдаа илэрснээс аудитын явцад 100.5 сая төгрөгийн 1 алдааг залруулж, шинж чанарын хувьд материаллаг байж болох 1 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Өмнөх онд оффисын барилга барихаар барилгын техникийн нөхцөлүүдэд төлсөн 100.5 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд зардлаар бүртгэж цэвэр ашгийг бууруулсан.

Аудитаар илэрсэн 759.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 759.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон 1,109.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Диспетчерийн үйл ажиллагааны нийт орлогын төлөвлөгөөг 1.1 хувь буюу 116.2 сая төгрөгөөр тасалдуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалттай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. "Нэмэлт ажил үйлчилгээ зохицуулах" журмын дагуу харгалзах зардлыг оновчтой зөв хуваарилалгүй 415.5 сая төгрөгийн урамшуулалт цалинг олгосон, зориулалт тодорхойгүй, ашиглалтгүй 228.0 сая төгрөгийн өртөгтэй Тоёота маркийн Ланд крузер-200 автомашиныг ТӨБЗГ-т хэрэгцээтэй газарт нь шилжүүлэх хүсэлт гаргаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно", 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэсэн заалттай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчилд албан шаардлага хүргүүлэх.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулахтай холбоотой асуудал



Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

Илрүүлэлт:

Тайлант онд Нэг худалдан авагчийн загварын тооцооны 58.338.5 сая төгрөгийн авлага, 54,871.4 сая төгрөгийн өглөгийг тайлагнасан. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтад авлага, өглөгийн насжилтыг тодорхойлоогүй, тайлан хэрэглэгчдэд ил тод тайлагнах зарчмыг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Нэг худалдан авагчийн загварын тооцооны авлага, өглөгийн насжилтын хугацаа, харилцагч байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг оруулан батлуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж					
		Тоо		Дун		Тоо		Дун		Зарлуулсан		Зарлуулаагүй		Тоо		Дун	
		Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун		
1	Өмнөх онд оффисын барилга барихаар барилгын техникийн нөхцөлүүдэд төлсөн 100.5 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд зардлаар бүртгэж цэвэр ашгийг бууруулсан.	1	100.5			1	100.5			1	100.5						
2	Тайлант онд Нэг худалдан авагчийн загварын тооцооны 58,338.5 сая төгрөгийн авлага, 54,871.4 сая төгрөгийн өглөгийг тайлагнасан. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтад авлага өглөгийн насжилтыг тодорхойлоогүй, тайлан хэрэглэгчдэд ил тод тайлагнах зарчмыг хэрэгжүүлээгүй.	1	-													1	-
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>100.5</b>			<b>1</b>	<b>100.5</b>			<b>1</b>	<b>100.5</b>				<b>1</b>	<b>-</b>	

#### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо		Дун		Тоо		Дун		Тоо		Тоо		Дун	
		Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун		
1	Диспетчерийн үйл ажиллагааны нийт орлогын төлөвлөгөөг 1.1 хувь буюу 116.2 сая төгрөгөөр тасалдуулсан байна.	1	116.2			1	116.2								
2	"Нэмэлт ажил үйлчилгээ зохицуулах" журмын дагуу харгалзах зардлыг оновчтой зөв хуваарилалгүй 415.5 сая төгрөгийн урамшуулалт цалинг олгосон	1	415.5			1	415.5								
3	Зориулалт тодорхойгүй, ашиглалтгүй 228.0 сая төгрөгийн өртөгтэй Тоёота маркийн Ланд крузер-200 автомашиныг ТӨБЗГ-г хэрэгцээтэй газарт нь шилжүүлэх хүсэлт гаргаагүй байна.	1	228.0			1	228.0								
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>759.7</b>			<b>3</b>	<b>759.7</b>								

Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 15 № 366/АО/1501027  
СНАГ-2023/102/НА-СТА-ТӨА  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Диспетчерийн үйл ажиллагааны нийт орлогын төлөвлөгөөг 1.1 хувь буюу 116,200,000.00 /нэг зуун арван зургаан сая хоёр зуун мянга/ төгрөгөөр тасалдуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Диспетчерийн үйл ажиллагааны орлогыг тасалсан зөрчлийг арилгах, холбогдох хууль, журамд нийцүүлэн ажиллах, төсвийг бодитой төлөвлөх, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням, Санхүү, эдийн засгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Т.Бямбажав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Ч.БОЛД

Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264430

Z:\Alban Shaardlaga\2023\0315 SNAG-3.Docs

0001080799

Диспетчерийн үндэсний төвийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 15 № 367/А 0150124

Улаанбаатар хот

СНАГ-2023/102/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад тайлант онд "Нэмэлт ажил үйлчилгээ зохицуулах" журмын дагуу харгалзах зардлыг оновчтой зөв хуваарилалгүй 415,500,000.00 /дөрвөн зуун арван таван сая таван зуун мянга/ төгрөгийн урамшуулалт цалинг олгосон, зориулалт тодорхойгүй, ашиглалтгүй 228,000,000.00 /хоёр зуун хорин найман сая/ төгрөгийн өртөгтэй Тоёота маркийн Ланд крузер-200 автомашиныг ТӨБЗГ-т хэрэгцээтэй газарт нь шилжүүлэх хүсэлт гаргаагүй, нийт 643,500,000.00 /зургаан зуун дөчин гурван сая таван зуун мянган/ төгрөгийн зөрчил байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Энэ хуулийн 3.1-т заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад томилолдолд автомашин ашиглахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй хэрэгжүүлэх, автомашины мэдээллийг ТӨБЗГ-т албан шугамаар хүргүүлж, шийдвэрлүүлэх, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням, Санхүү, эдийн засгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан Т.Бямбажав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

ДИ ЭЙ БИ ЖЭИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Ч.БОЛД

Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264330

9023030583

Z:\Alban Shaardlaga\2023\0115 SNAГ-3.Docx

0001080797